



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/121/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.6.3 Нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Залруулсан алдаа	21
4.2 Төлбөрийн акт	21
4.3 Албан шаардлага	21
4.4 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
ЗГБНҮГ	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот төрийн үйлчилгээний газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХОҮХ	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/421
танай _____ -ны № _____ -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	566,315,569.10	180,938,048.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	435,028,433.00	120,503,173.78
312	Банканд байгаа бэлэн мөнгө	435,028,433.00	120,503,173.78
3121	Төгрөг	435,028,433.00	120,503,173.78
31211	Төрийн сангийн харилцах	-	5,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	435,028,433.00	120,498,173.78
33	АВЛАГА	3,029,984.07	5,204,659.02
33402	Татвар, НДШ – ийн авлага	1,810,183.63	5,204,659.02
3351	Бусад авлага	1,219,800.44	-
3352	Байгууллагаас авах авлага	1,219,800.44	-
34	УРЬДЧИЛГАА	4,731,100.00	21,378,900.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,731,100.00	21,378,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	123,526,052.03	33,851,315.23
354	Хангамжийн материал	123,526,052.03	33,851,315.23
35410	Бичиг хэргийн материал	84,595,146.80	7,770,090.00
35420	Аж ахуйн материал	12,263,714.00	4,491,093.00
35440	Түлш, шатах тослох материал	1,325,095.00	2,709,072.00
35470	Бусад хангамжийн материал	25,342,096.23	18,881,060.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,671,781,758.78	3,900,298,562.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,671,781,758.78	3,900,298,562.42
392	Биет хөрөнгө	1,667,636,458.78	1,888,430,262.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,549,894,744.40	1,514,439,398.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(210,958,987.33)	(267,754,491.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	375,900,000.00	791,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(220,747,499.79)	(352,420,888.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	642,729,657.39	671,027,039.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(526,905,103.36)	(515,300,174.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	342,486,878.86	328,884,127.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(284,904,231.39)	(281,644,748.23)
39217	Ном фонд	141,000.00	-
393	Биет бус хөрөнгө	2,004,145,300.00	2,011,868,300.00
39301	Программ хангамж	43,674,700.00	38,037,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(41,730,200.00)	(28,369,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,002,200,800.00	2,002,200,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,238,097,327.88	4,081,236,610.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	327,775.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	327,775.62
413	Өглөг	-	327,775.62
4136	Бусад өглөг	-	327,775.62
41361	Байгууллагад төлөх өглөг	-	162,812.23
41363	Татварын өглөг	-	164,963.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,238,097,327.88	4,080,908,834.83
51	Засгийн газрын хувь оролцоо	4,238,097,327.88	4,080,908,834.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,873,278,140.11	7,873,278,140.11
51101	Өмч: - төрийн	7,873,278,140.11	7,873,278,140.11
512	Хуримтлагдсан үр дүн	(3,881,187,740.12)	(4,038,109,830.53)
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,881,187,740.12)	(3,880,921,337.48)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(157,188,493.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	246,006,927.89	245,740,525.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,238,097,327.88	4,081,236,610.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	/төгрөгөөр/ ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,687,163,587.79	6,041,731,731.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	442,407,327.79	608,101,051.80
120	Нийтлэг татварын бус орлого	442,407,327.79	608,101,051.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	244,431,315.79	468,234,201.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	171,099,582.60	73,090,366.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,331,733.19	395,143,834.22
120009	Бусад орлого	197,976,012.00	139,866,850.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,244,756,260.00	5,433,630,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,146,999,260.00	5,133,203,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,146,999,260.00	5,133,203,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,757,000.00	300,427,380.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,757,000.00	300,427,380.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,418,304,906.76	6,172,161,445.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,418,304,906.76	6,172,161,445.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,231,114,193.97	5,395,452,081.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,668,866,974.92	3,681,689,702.67
210101	Үндсэн цалин	3,668,866,974.92	2,672,936,341.42
210102	Нэмэгдэл	-	658,327,861.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	350,425,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	461,003,503.90	473,441,334.83
210201	Тэтгэврийн даатгал	315,736,438.90	328,522,241.91
210202	Тэтгэмжийн даатгал	36,680,085.00	37,231,912.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,061,830.00	29,436,090.14
210204	Ажилгүйдлийн даатгал	7,229,560.00	7,107,189.99
210205	Эрүүл мэндийн даатгал	72,295,590.00	71,143,900.55
2104	Хангамж, бараа материалын зардал	114,887,244.29	166,466,215.75
210401	Бичиг хэрэг	37,234,317.00	21,088,040.44
210402	Тээвэр, шатахуун	9,473,874.00	7,349,483.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,546,890.29	31,554,878.31
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,632,163.00	81,146,444.00
210408	Бараа материал акталсны зардал	-	25,327,370.00
2105	Норматив зардал	1,748,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,748,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,544,660.00	1,319,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,000.00	-
210604	Урсгал засвар	23,479,660.00	1,319,140.00
2107	Томиллолт, зочны зардал	90,879,553.00	59,419,819.00
210702	Дотоод албан томиллолт	90,879,553.00	59,419,819.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,805,313.33	402,648,956.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	279,383,380.00	276,621,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,280,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	392,040.00	800,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	512,568.00	739,932.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,085,262.73	32,606,617.56
210807	Газрын төлбөр	1,496,040.00	1,496,040.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	186,634,022.60	90,383,866.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	369,378,944.53	610,466,913.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,720,823.00	414,505,202.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,658,121.53	195,961,711.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,187,190,712.79	790,884,363.66

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,836,488.00	17,995,554.84
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	8,836,488.00	17,995,554.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,015,233.00	303,936,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	54,188,273.00	73,221,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	157,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,826,960.00	73,465,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	293,760,540.69	123,032,880.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	293,760,540.69	123,032,880.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,780,578,451.10	345,919,328.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,673,801,227.10	345,919,328.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	1,106,777,224.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,731,141,318.97)	(130,429,713.75)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	82,751,922.00	26,758,779.30
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	82,751,922.00	508,779.70
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	26,249,999.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(82,751,922.00)	(26,758,779.30)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,813,893,240.97)	(157,188,493.05)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

<i>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон</i>				<i>/төгрөгөөр/</i>
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873,278,140.11	246,006,927.89	927,898,393.12	9,047,183,461.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,873,278,140.11	246,006,927.89	927,898,393.12	9,047,183,461.12
Тайлант үеийн үр дүн	-	-	(4,809,086,133.24)	(4,809,086,133.24)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873,278,140.11	246,006,927.89	(3,881,187,740.12)	4,238,097,327.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	266,402.64	266,402.64
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,873,278,140.11	246,006,927.89	(3,880,921,337.48)	4,238,363,730.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(266,402.64)	-	(266,402.64)
Тайлант үеийн үр дүн	-	-	(157,188,493.05)	(157,188,493.05)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873,278,140.11	245,740,525.25	(4,038,109,830.53)	4,080,908,834.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,617,866,854.60	5,646,587,897.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	369,075,594.60	212,957,217.58
120	Нийтлэг татварын бус орлого	369,075,594.60	212,957,217.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	171,099,582.60	73,090,366.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	171,099,582.60	73,090,366.80
120009	Бусад орлого	197,976,012.00	139,866,850.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,248,791,260.00	5,433,630,680.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,146,999,260.00	5,133,203,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,146,999,260.00	5,133,203,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,792,000.00	300,427,380.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,757,000.00	300,427,380.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,035,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,329,864,046.70	5,904,739,696.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,329,864,046.70	5,904,739,696.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,141,868,333.91	5,113,855,333.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,666,183,077.78	3,676,466,800.00
210101	Үндсэн цалин	2,581,143,983.28	2,671,563,933.41
210102	Нэмэгдэл	870,573,094.50	656,923,611.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	214,466,000.00	347,979,254.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	466,770,725.11	479,029,309.06
210201	Тэтгэврийн даатгал	349,693,928.12	334,110,216.14
210202	Тэтгэмжийн даатгал	29,741,260.24	37,231,912.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,209,929.85	29,436,090.14
210204	Ажилгүйдлийн даатгал	5,887,052.29	7,107,189.99
210205	Эрүүл мэндийн даатгал	60,238,554.61	71,143,900.55
2104	Хангамж, бараа материалын зардал	112,372,700.29	107,740,917.52
210401	Бичиг хэрэг	26,119,341.00	24,378,350.44
210402	Тээвэр, шатахуун	10,265,600.00	12,274,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,546,890.29	31,582,866.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,440,869.00	39,504,741.00
2105	Норматив зардал	2,178,500.00	3,138,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,178,500.00	3,138,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,143,779.00	34,251,569.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,664,119.00	12,898,699.00
210604	Урсгал засвар	23,479,660.00	31,966,870.00
2107	Томилолт, зочны зардал	79,169,823.00	55,787,859.00
210702	Дотоод албан томилолт	79,169,823.00	55,787,859.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	541,862,975.73	343,127,916.56

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	279,383,380.00	276,621,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,280,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	392,040.00	800,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	503,568.00	604,932.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,378,262.73	43,696,844.56
210807	Газрын төлбөр	1,496,040.00	1,496,040.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	223,407,685.00	19,863,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	231,186,753.00	414,312,162.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	231,186,753.00	414,312,162.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,187,995,712.79	790,884,363.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,836,488.00	17,995,554.84
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	8,836,488.00	17,995,554.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,820,233.00	303,936,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	54,993,273.00	73,221,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	157,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,826,960.00	73,465,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	293,760,540.69	123,032,880.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	293,760,540.69	123,032,880.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,780,578,451.10	345,919,328.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,673,801,227.10	345,919,328.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	1,106,777,224.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(4,711,997,192.10)	(258,151,799.22)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	56,373,460.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	56,373,460.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	56,373,460.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	56,373,460.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(56,373,460.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(4,711,997,192.10)	(314,525,259.22)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,147,025,625.10	435,028,433.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	435,028,433.00	120,503,173.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,144,883,300.00	5,083,328,785.98	61,554,514.02	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,144,883,300.00	5,083,328,785.98	61,554,514.02	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,810,501,200.00	4,761,396,631.14	49,104,568.86	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,676,466,800.00	3,676,466,800.00	-	100.0
210101	Үндсэн цалин	2,302,261,800.00	2,671,563,933.41	(369,302,133.41)	116.0
210102	Нэмэгдэл	1,029,685,000.00	656,923,611.76	372,761,388.24	63.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	344,520,000.00	347,979,254.83	(3,459,254.83)	101.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	496,322,900.00	479,029,309.06	17,293,590.94	96.5
210201	Тэтгэврийн даатгал	349,264,300.00	334,110,216.14	15,154,083.86	95.7
210202	Тэтгэмжийн даатгал	36,764,700.00	37,231,912.24	(467,212.24)	101.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,411,700.00	29,436,090.14	(24,390.14)	100.1
210204	Ажилгүйдлийн даатгал	7,352,900.00	7,107,189.99	245,710.01	96.7
210205	Эрүүл мэндийн даатгал	73,529,300.00	71,143,900.55	2,385,399.45	96.8
2104	Хангамж, бараа материалын зардал	122,068,000.00	108,275,477.52	13,792,522.48	88.7
210401	Бичиг хэрэг	32,655,000.00	24,378,350.44	8,276,649.56	74.7
210402	Тээвэр, шатахуун	12,275,000.00	12,274,960.00	40.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,986,500.00	31,582,866.08	5,403,633.92	85.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,151,500.00	40,039,301.00	112,199.00	99.7
2105	Норматив зардал	3,497,500.00	3,138,800.00	358,700.00	89.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,497,500.00	3,138,800.00	358,700.00	89.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,685,600.00	76,680,469.00	5,131.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,718,700.00	44,713,599.00	5,101.00	100.0
210604	Урсгал засвар	31,966,900.00	31,966,870.00	30.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	63,626,800.00	55,787,859.00	7,838,941.00	87.7
210702	Дотоод албан томилолт	63,626,800.00	55,787,859.00	7,838,941.00	87.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	366,208,600.00	356,537,916.56	9,670,683.44	97.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,005,400.00	276,621,680.00	383,720.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	-	1,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,510,800.00	800,820.00	709,980.00	53.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	920,000.00	604,932.00	315,068.00	65.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	310,000.00	44,000.00	266,000.00	14.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	57,230,800.00	57,106,844.56	123,955.44	99.8
210807	Газрын төлбөр	1,496,100.00	1,496,040.00	60.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26,235,600.00	19,863,600.00	6,372,000.00	75.7

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,625,300.00	5,480,000.00	145,000.00	97.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,625,300.00	5,480,000.00	145,000.00	97.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	334,382,100.00	321,932,154.84	12,449,945.16	96.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	29,680,000.00	17,995,554.84	11,684,445.16	60.6
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	29,680,000.00	17,995,554.84	11,684,445.16	60.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	304,702,100.00	303,936,600.00	765,500.00	99.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	73,236,500.00	73,221,000.00	15,500.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	158,000,000.00	157,250,000.00	750,000.00	99.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,465,600.00	73,465,600.00	-	96.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,144,883,300.00	5,083,328,785.98	61,554,514.02	98.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,144,883,300.00	5,083,328,785.98	61,554,514.02	98.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,144,883,300.00	5,083,632,708.71	61,554,514.02	98.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	145	145	-	100.0
620001	Удирдах ажилтан	18	18	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	122	122	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	300,427,380.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	300,427,380.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	300,427,380.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,427,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,427,380.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	300,427,380.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	300,427,380.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,427,380.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, гэрээт аудитор О.Наранбат нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/336 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зам, тээврийн хөгжлийн яам нь Зам, тээврийн салбарын хөгжлийн нэгдсэн болон хүний нөөцийн бодлого, автозам, авто тээвэр, төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээвэр, иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, салбар хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг зохицуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, салбарын стандарт, норм, норматив, техник, технологи, судалгаа шинжилгээг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудитын хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор баталсан Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 онд харьяа байгууллага, сан, төсөл хөтөлбөрийн санхүү болон шилэн дансны үйл ажиллагаанд 15 удаагийн дотоод аудит хийж гүйцэтгэн, батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 5 газрыг хамруулан, 2,064,158.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2,600.0 мянган төгрөгийн 2 акт, 2,061,558.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилт 93.7 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,172,195.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 92,582.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 156,860.7 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянга төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	435,028.4	120,503.2	(314,525.2)
Авлага	3,030.0	5,204.7	2,174.7
Урьдчилгаа	4,731.1	21,378.9	16,647.8
Бараа материал	123,526.0	33,851.3	(89,674.7)
Үндсэн хөрөнгө	3,671,781.8	3,900,298.5	228,516.8
Нийт хөрөнгө	4,238,097.3	4,081,236.6	(156,860.7)
Өр төлбөр	-	327.8	327.8
Засгийн газрын хувь оролцоо	4,238,097.3	4,080,908.8	(157,188.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,238,097.3	4,081,236.6	(156,860.7)

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 120,503.2 мянган төгрөг болж, 314,525.2 мянган төгрөгөөр буурсан нь техник хяналтын дансны эхний үлдэгдлээс Үндэсний аудитын газрын 01/А0170067 дугаар актын төлбөр 345,919.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 5,204.7 мянган төгрөг болж, 2,174.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд ажилчидтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэл 3,394.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй холбоотой авлага үүссэнээс шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 21,378.9 мянган төгрөг болж, 16,647.8 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчдын ажлын нөхцөлийн сайжруулах зорилгоор компьютерын хурд нэмэгдүүлэх хатуу дискийн 11,000.0 мянга, программын хөгжүүлэлт, яамны цахим хуудасны хэрэглээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй эсэх, мэдээллийн системд үнэлгээ хийх 3,260.0 мянга, хангамжийн бараа материал 7,118.9 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,851.3 мянган төгрөг болж, 89,674.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 129,953.4 мянган төгрөгийн бичиг хэрэг, түлш, шатахуун, хангамжийн материал худалдан авч, 194,532.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 25,327.4 мянган төгрөгийн 58 нэр төрлийн 346 ширхэг бараа материалыг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/07 тушаалаар акталж, данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,900,298.5 мянган төгрөг болж, 228,516.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны дараах хөрөнгийн шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалсан байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн орлого:

- Иргэний нисэхийн ерөнхий газраас ТӨБЗГ-ын 2021 оны “Хариу хүргүүлэх тухай” А-1/450 дугаар албан бичгээр 147,300.0 мянган төгрөгийн өртөгтэй Ландкрузейр-200 маркын автомашиныг;
- Иргэний нисэхийн ерөнхий газраас ТӨБЗГ-ын 2021 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 361 дүгээр тогтоолоор 159,800.0 мянган төгрөгийн өртөгтэй Ландкрузер-200, мөн 67,200.0 мянган төгрөгийн Тоёота хайс маркийн автомашиныг;
- ТӨБЗГ-ын 2021 оны “Хариу хүлээн авах тухай” А-1/2229 дүгээр албан бичгээр 169,000.0 мянган төгрөгийн Ландкрузейр-200 маркийн автомашиныг;
- ЗГБНҮГ ТӨААТҮГ-аас ТӨБЗГ-ын 2021 оны “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 203 дугаар тогтоолоор 2 нэр төрлийн нийт 20,401.2 мянган төгрөгийн галын дохиоллын систем, цахилгааны самбарыг;
- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-аас ТӨБЗГ-ын 2021 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 433 дугаар тогтоолоор 6 нэр төрлийн 20,052.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг;
- Зам, тээврийн хөгжлийн төв УТҮГ-аас ТӨБЗГ-ын 2021 оны “Хариу хүргүүлэх тухай” А-1/2230 дугаар албан бичгээр 11,786.6 мянган төгрөгийн компьютер, ариутгалын хаалгыг тус тус балансаас балансад шилжүүлэн авч бүртгэсэн;
- Урсгал үйл ажиллагааны зардлаас 56,373.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ худалдан авсан дүнгээр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн зарлага:

- ТӨБЗГ-ын 2021 оны “Үндсэн хөрөнгө данснаас хасах, засаж сэлбэн орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 76 дугаар тогтоолоор Сүхбаатар аймгийн Асгат сумын ЗДТГ-т 128,000.0 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Ландкрузер-200 маркийн автомашиныг балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны “Албан бичгийн хариу” А-1/1880 дугаар албан бичгээр 150 нэр төрлийн 53 ширхэг 24,829.6 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасах;

- ТӨБЗГ-ын 2022 оны “Албан бичгийн хариу” А-1/123 дугаар албан бичгээр 82 нэр төрлийн 147 ширхэг 74,445.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасах;
- ТӨБЗГ-ын 2021 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 326 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 455.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, үлдэгдэл өртгөөр нь хоёрдогч түүхий эд болгон худалдах данснаас хасах;
- ТӨБЗГ-ын 2021 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 327 дугаар тогтоолоор 35,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,080,908.8 мянган төгрөг болж, 157,188.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүн нөлөөлснөөс шалтгаалжээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 354,568.1 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 4,246,143.5 мянган төгрөгөөр буюу 40.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого болон нэмэлт санхүүжилтийн орлого, бараа үйлчилгээний бусад зардал, төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг данс байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 223,802.9 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын тогтоолоор балансаас балансад 395,143.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 202,670.4 мянган төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” 44 дүгээр тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцин тээвэрлэх нислэгийн зардал 279,241.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос шалтгаалжээ.

Бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос 88,385.3 мянган төгрөгөөр буурсан нь тээврийн хэрэгслийн гэрчилгээ хэвлүүлэх үйл ажиллагааг харьяа байгууллагад шилжүүлсэн тул улсын мэдээллийн маягт хэвлүүлэх, бэлтгэх зардлаас 93,825.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилтийн данс өмнөх оноос 4,434,659.1 мянган төгрөгөөр буурсан нь Үндэсний аудитын газраас 2020 онд 4,780,578.4 мянган төгрөгийн төлбөрийн акт төвлөрүүлж байсан бол тайлант онд 345,919.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлгээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,082,134.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт 1,922,623.2 мянган төгрөгөөр буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 651,772.6 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлаас 87,989.4 мянга, бараа материалын зардлаас 98,262.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 92,975.0 мянга, томилолтын зардлаас 207,638.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 439,035.0 мянган төгрөгийг тус тус бууруулж, 5,159,510.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээрх батлагдсан төсвөөс 14,627.5 мянган төгрөгийн дутуу санхүүжилт олгож, мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд гэрчилгээний үнэ 73,090.4 мянга, төсвийн хэмнэлт 49,942.5 мянга, нийт 123,032.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийг бодитой төлөвлөн зарцуулсан байгааг харуулж байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх 5,144,883.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,133,203.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагааны зардалд 5,083,328.8 мянган төгрөгийг зарцуулж, 49,874.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,083,328.8 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 17,293.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 13,792.5 мянга, дотоод албан томилолтын зардлыг 7,838.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг 61,554.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны зардлын арга хэмжээг 48,720.8 мянга, олон улсын байгууллагын гишүүнчлэл хураамжийн арга хэмжээг 11,684.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71107	Зам тээврийн бодлого удирдлага	5,144,883.3	5,083,328.8	61,554.5	98.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,533,495.8	4,484,775.0	48,720.8	98.9
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	3,805.8	3,422.5	383.3	89.9
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	273,199.6	273,199.2	0.4	100.0
1.4	80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж	29,680.0	17,995.6	11,684.4	60.6
1.5	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмадад	158,000.0	157,250.0	750.0	99.5
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	146,702.1	146,686.6	15.5	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” 44 дүгээр тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцин тээвэрлэх нислэгийн зардал 279,281.4 мянга, Засгийн газрын 2020 оны “Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай” 172 дугаар тогтоолыг үндэслэн “Старт прожект” ХХК-тай 2020 оны “Зураг төслийн ажил гүйцэтгэх” 20/15 дугаар гэрээ байгуулан 21,146.0 мянган төгрөгийн санхүүжилт, нийт 300,427.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, 68.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 300,359.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээний хэрэгжилт 87.7 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.8 хувийн биелэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 148 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 29,615.2 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 16,050.0 мянган төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.4.5-д *“цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д *“төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/15 дугаар, Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн урсгал санхүүжилтийн данснаас бэлтгэх 31,343.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны цахим тендерт хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэн хүлээлгэн өгч, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн үзүүлэлттэй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,651,384.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлж, 159,447.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлж, 30,311.3 мянган төгрөгийн албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 18,329.6 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт /аудитын явцад/	2	1,651,384.4	2	1,651,384.4	-	-	100.0
Албан шаардлага	2	189,759.2	1	159,447.9	1	30,311.3	84.0
Зөвлөмж	5	18,329.6	5	18,329.6	-	-	100.0
Нийт дүн	9	1,859,473.2	8	1,829,161.9	1	30,311.3	94.7

Төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх 30,311.3 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй тул төлбөрийн акт тогтоож хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолын хэрэгжилт, мөн авто зам, замын байгууламжийн техник технологийн хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийн хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 371,537.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 279,887.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 30,311.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 56,373.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4,965.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 91,650.3 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс 92,582.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланг 104,553.7 мянган төгрөгөөр зардал хооронд гүйлгэн алдаатай илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг 7,830.0 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд 56,373.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтыг дутуу илэрхийлсэн;
- Нэмэлт санхүүжилтийн дансанд 108,404.8 мянган төгрөгийн техник хяналтын зардлын гүйлгээг илүү тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтийн зардлын эх үүсвэрийг 2,725.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

4.2 Төлбөрийн акт

Өмнөх оны аудитаар төрд учруулсан 30,311.3 мянган төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин 56,373.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 296 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.6-д заасныг үндэслэн 61 албан хаагчид 30,300.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй

байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 701,876.8 мянган төгрөгийн 878 ширхэг хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй, арга хэмжээ авч ажиллаагүй нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах", 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авч ажиллах;

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Урсгал засвар үйлчилгээ хийгдсэн 4,965.5 мянган төгрөгийн зарцуулалтад гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Урсгал засвар үйлчилгээ хийгдсэн ажил, гүйлгээнд ажлын тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, баримтын бүрдлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Байгууллагын нэр Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Зам, тээврийн хөгжлийн яам АХГ- 2022/121/НА- СТА-ТШЗ	Санхүүгийн үр дүнгийн тайланг 104,553.7 мянган төгрөгөөр зардал хооронд гүйлгэн алдаатай илэрхийлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	104,553.7	1	104,553.7							
2		Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг 7,830.0 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	7,830.0	1	7,830.0							
3		Мөнгөн гүйлгээний тайланд 56,373.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтыг дутуу илэрхийлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	56,373.5	1	56,373.5							
4		Нэмэлт санхүүжилтийн дансанд 108,404.8 мянган төгрөгийн техник хяналтын зардлын гүйлгээг илүү тайлагнасан байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	108,404.8	1	108,404.8							
5		Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтийн зардлын эх үүсвэрийг 2,725.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.	Санхүүгийн тайланд залруулах	1	2,725.6	1	2,725.6							
6		Өмнөх оны аудитаар төрд учруулсан 30,311.3 мянган төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Төлбөрийн акт тогтоох	1	30,311.3			1	30,311.3					
7		ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 296 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.6-д заасныг үндэслэн 61 албан хаагчид 30,300.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан олгосон байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-			
8		Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин 56,373.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу бүртгээгүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	56,373.5					1	56,373.5			
9		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 701,876.8 мянган төгрөгийн 878 ширхэг хөрөнгөнд дахин үнэлгээ хийгдээгүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.	Зөвлөмж өгөх	1	-								1	-

**Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

10		Урсгал засвар үйлчилгээ хийгдсэн 4,965.5 мянган төгрөгийн зарцуулалтад гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	Зөвлөмж өгөх	1	4,965.5								1	4,965.5	
ДҮН				10	371,537.9	5	279,887.6	1	30,311.3	2	56,373.5	-	-	2	4,965.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал															
1	Зам, тээврийн хөгжлийн яам АХГ-2022/121/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд нийт 148 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 29,615.2 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 16,050.0 мянган төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-				
ДҮН				1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
НИЙТ ДҮН				11	371,537.9	5	279,887.6	1	30,311.3	3	56,373.5	-	-	2	4,965.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 19/АД160069
АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар төрд учруулсан 30,311,265.00 төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төрд учруулсан 30,311,265.00 /гучин сая гурван зуун арван нэгэн мянга хоёр зуун жаран таван/ төгрөгийн хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллан, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга М.Энхболд, ерөнхий нягтлан бодогч Г.Алтангэрэл нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тайруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
9019120396

W10.10.10\0\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-5.Docx

001090020



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 59/АД160064
АХГ-2022/121/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин 56,373,460.00 /тавин зургаан сая гурван зуун далан гурван мянга дөрвөн зуун жаран/ төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу бүртгээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, ерөнхий нягтлан бодогч Г.Алтангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264238

9006109
9019120506
\\10.10.20\Bichig\Thereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-9.Docx

001081610



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 25 № 60/АЧН/0069
АХГ-2022/121/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 148 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 29,615,168.00 /хорин есөн сая зургаан зуун арван таван мянга нэг зуун жаран найман/ төгрөгийн 3 гүйлгээ, 16,050,000.00 /арван зургаан сая тавин мянган/ төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, ерөнхий нягтлан бодогч Г.Алтангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
90191203 \\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-7.Docx

001081604



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 08 дугаар сарын 25 № 61/АД/160064
АХГ-2022/121/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 296 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.6-д заасныг үндэслэн 61 албан хаагчид 30,300,000.00 /гучин сая гурван зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, ерөнхий нягтлан бодогч Г.Алтангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-8.Docx

001081608